

History of the XX Century Mongolia

1921 revolution : 1917 revolution in Russia

Lecture 5

Lecturer: Prof. OTGONJARGAL Sodnomdarjaa

National University of Mongolia

XX зууны Монголын ТҮҮХ

1921 оны хувьсгал: Орос дахь 1917 оны хувьсгал

Лекц 5

Проф.ОТГОНЖАРГАЛ Содномдаржаа

Монгол Улсын Их Сургууль

Лекцийн агуулга


- Энэ лекцээрээ бид олон зуун жилээр бэлтгэгдэж ирсэн улс орны хөгжлийн оюун ухаан болсон язгууртнууд элитүүдээ устгасан төрийн эргэлтийн тухай мэдэх болно.
- Энэхүү төрийн эргэлт хүний сэтгэлгээний эрх чөлөөг хэрхэн хааж үндэстнийг мөхлийн зам руу оруулж болохыг ойлгож авна.

1917 оны октябрь хэмээх 10 дугаар сард
Орос улсад социалист хувьсгал гарав.
Энэхүү хувьсгалыг гардан удирдагч нь
В.И Ленин байсан бөгөөд марксизмын
онолыг удирдлагаа болгосон нэгэн байв.



Уг онол нь нийгмийг өмчтэй, өмчгүй гэж хоёр хэсэгт хувааж, хоорондоо эвлэрэшгүй зөрчилтэй хэмээн номлож, зөвхөн зэвсэгт бослогоор, пролетарийн диктатурын замаар мөлжигчдийг устгаж, коммунизмыг буюу өмчгүй нийгмийг байгуулж болох тухай зааж байлаа.





Өмчгүйчүүдийн эрх ашгийг хамгаалсан, хувийн өмчийг устгаж
бүх нийтийг ижил тэгш эрхтэй болгох зорилго агуулсан урьд өмнө
гарч байгаагүй уг үйл явдал нь хувийн өмчийг дээдлэн амьдарч
ирсэн Монгол улсыг төдийгүй капиталист томоохон гүрнүүдийг
цочролд оруулсан юм.

Олон зуун жилээр бэлтгэгдэж төрийн Оюун Ухаан болсон язгууртнууд, элитүүдээ гудамжинд гаргаж бичиг үсэгт ч тайлагдаагүй ажилчин тариачдыг Орос Улсын тархинд гаргасан явдал нь Гегелийн хэлсэнчлэн хүн хоёр хөл дээрээ явж ханалаа одоо толгойгоороо явж үзье гэхийг диалектик сэтгэлгээ гэж үзвэл дэндүү том эндүүрэл гэсэнтэй нэгэн адил зүйл байв.



<https://kateshrewsday.com/2013/05/06/the-secret-aristocrats-russians-in-hiding/>

Ийнхүү Зөвлөлт засаг тогтмогц жижиг буурай орнуудыг ямар ч хамаагүй замаар өөртөө нэгтгэх аргыг эрэлхийлэх болов. Монголын Засгийн газар “Большевик хувьсгалыг “самуун хэрэг”, улаантныг “самуун намын хүн” хэмээн үзэж , Троицкосавскт Зөвлөлт засаг тогтоход Нийслэл Хүрээнээс түшмэл Пунцагаар удирдуулсан дөрвөн аймгийн 300 цэргийг Хиагтад 1918 оны хавар шилжүүлэн байршуулсан байна.

Бүрэн эрхээ хязгаарлуулсан Тусгаар Тогтнол 1921-1925, Болд Р, Нэпко ХХК, 2021



<https://www.sonin.mn/news/culture/121397>

Улаан Оросууд Монголын хил хязгаарыг зөрчсөөр байгааг өөртөө ашигтайгаар эргүүлэхээр Дундад улсын зүгээс монголчуудыг хамгаалах нэрийн дор Монголд цэргээ оруулах хүсэлтийг 1918 оны хавар Монголын Засгийн газарт уламжилжээ.




https://en.wikipedia.org/wiki/Bogd_Khan

Хятадын талын шахалтыг Монголын тал хүлээж авснаар Хятадын морьт хороо 1918 оны 9 дүгээр сарын 3-нд Хүрээнд орж иржээ. Хятад улс цэргээ татсангүй 3000 мянган хүний бүрэлдэхүүнтэй бригадын 2 хороо 9 дүгээр сарын туршид цувран Хүрээнд ирсэн бол 8 дугаар хороо нь 1919 оны 10 дугаар сарын 29-нд генерал Сүй-Шү-Жаны хамт иржээ.

“Бүрэн эрхээ хязгаарлуулсан Тусгаар Тогтнол 1921-1925”, Болд Р, Нэпко ХХК, 2021.

х.35\



<https://www.sonin.mn/news/enews/84709>

1919 онд ийнхүү Сүй Шү Жан тэргүүтэй хятадын эзлэн түрэмгийлэгчид Монголын хилийг хамгаалах нэрийн дор Монголд цэрэглэн орж ирсэнээр монголын тусгаар тогтнолд аюул занал бодитоор нүүрэлсэн юм.




Хятадын их цэргийн сүр хүчин дор монголын Дээд Доод
хурлыг татан буулгав.

Хүрээнд Хятад улсын төлөөний яам хэмээх Баруун хойд
хязгаарын хэргийг бодуулан шийтгэгч яам байгуулагдаж
Монголын засгийн газрыг түүнд нэгтгэж бүхий л эрхийг уг
яаманд шилжүүлэв.

Түүхэн энэ үед Дээд хурлын гишүүдээс Ноёдын намыг байгуулж байхад Доод хурлын гишүүд голдуу орсон Хүрээний \Түшмэдийн\ болон Консулын нууц бүлгэмүүд мөн байгуулагджээ. Энэхүү нам бүлгэмүүд Богд хаант засгийн газраа түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байв.





Энэ лекцээрээ бид 1917 оны Оросод болсон төрийн эргэлтийн уршгаар Монгол улс тусгаар тогтнолоо алдаж , сэтгэлгээний эрх чөлөөг хязгаарласан нийгэм рүү орох ЭХЛЭЛ тавигдсаныг мэдэж авлаа.

Reference

1. Бүрэн эрхээ хязгаарлуулсан Тусгаар Тогтнол 1921-1925, Болд Р, Нэпко ХХК, 2021
2. Монгол улсын шинэ түүх, Магсаржав Н, Монсудар, 2010
3. Философия истории, ГегСанкт-Петербургель Г.В.Ф., “Наука”, 1993

Анхаарал тавьсанд баярлалаа